



Боловсрол, Шинжлэх Ухааны Яамны харьяа

# БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

#8 (17)

2023 он

VIII сар

Сар тутмын хэвлэл

 <http://www.mnier.mn>

## ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН МЕНЕЖМЕНТИЙГ ДЭМЖИХ АРГА ЗҮЙН ЗӨВЛӨМЖИЙГ ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ АЖИЛ ХИЙГДЭВ



Ерөнхий боловсролын сургуулийн менежментийг дэмжих арга зүйн зөвлөмж боловсруулав.

БШУ-ны сайдын 2023 оны А/01 дугаартай тушаалаар 2023 оны сургалтын байгууллагын менежментийг сайжруулах жил болгон зарласан бөгөөд үүнтэй холбогдуулан “сургуулийн менежментийн загвар” бүхий зөвлөмж боловсруулсан. Сургуульд суурилсан менежментийг үр дүнтэй хэрэгжүүлэх, сургуулийн хөгжлийг хангахад удирдлага, хамт олонд арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилго бүхий тус зөвлөмжийг БЕГ, БСҮХ, БҮТ, НБГ, Их, дээд сургууль, төсөл хөтөлбөрийн төлөөлөл хамтран боловсруулав.



Зөвлөмжид дараах агуулгыг багтаасан. Үүнд:

1 дүгээр бүлэг: Боловсролын Ерөнхий хууль, СӨБ болон Ерөнхий Боловсролын хууль, ирээдүйн чиг хандлага болон олон улсын богино, дунд, урт хугацааны менежментийг үр дүнтэй хэрэгжүүлэх загвар, аргачлал, сургуулийн өөрийн үнэлгээний хэрэгсэл

2 дугаар бүлэг: БҮТ-ийн цахим тоон тайлангийн системээс сургуулийн менежментээ сайжруулахад дэмжлэг үзүүлэх зөвлөн туслах үйл ажиллагаанд хамрагдсан 84 сургуулийн асуудал, асуудлыг шийдвэрлэж буй байдал туршлагад тулгуурласан мэдээлэлд шинжилгээ хийх аргачлал

3 дугаар бүлэг: Менежментийн зураглал, сургуулийн нэгдсэн төлөвлөгөө боловсруулах арга аргачлал, түүнийг хэрэгжүүлэх явцын үнэлгээ хийх арга аргачлал

Сургуулийн менежментийг сайжруулахад хамт олны оролцоог хангах, ахиц, өөрчлөлтийг бодитойгоор тодорхойлох, сургуулийн хөгжлийг хангахад зөвлөмжийн ач холбогдол оршиж байна.

## **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН МЕНЕЖМЕНТИЙГ ДЭМЖИХ АРГА ЗҮЙН ЗӨВЛӨМЖИЙГ ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ СУРГАГЧ БАГШИЙН СУРГАЛТ ЯВАГДЛАА**

Боловсролын бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сургуулийн менежментийг дэмжих арга зүйн зөвлөмжийг сургагч багш нарт таниулах, түгээн дэлгэрүүлэх сургалтад БЕГ, БСҮХ, БҮТ-ээс 76 хүн оролцлоо.



## **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН МЕНЕЖМЕНТИЙГ ДЭМЖИХ АРГА ЗҮЙН ЗӨВЛӨМЖИЙГ ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ СУРГАЛТ ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА**

2023-2024 оны хичээлийн жилийн зорилго, зорилтын хүрээнд орон нутаг боловсролын бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сургуулийн менежментийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилго бүхий сургалтыг 2023 оны 8 дугаар сарын 23-24-ний өдрүүдэд зохион байгуулав. Сургалтад НБГ, дүүргийн боловсролын хэлтэс, бүх аймгийн БШУГ-ын дарга, мэргэжилтэн, ЕБС-ийн захирал, нийт 800 орчим хүн хамрагдсан байна.



Сургалтаар “Сургуулийн менежментийг дэмжих арга зүйн зөвлөмж”-ийг таниулах, сургуулийн менежментийг оновчтой хэрэгжүүлэх мэдлэг, чадварыг дээшлүүлэх, төлөвлөлт, тайлан боловсруулах арга, аргачлалтай болоход чиглэсэн 7 үйл ажиллагааны хүрээнд 11 дадлага ажлыг хийж, оролцогчдын мэдлэг, ойлголтыг нэгтгэсэн байна.

## МАТЕМАТИКИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ДЭМЖИХ "EDUTEN" ЦАХИМ СИСТЕМИЙГ ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНД АШИГЛАХ БОЛОО



БШУ-ны сайдын 2023 оны А/312 дугаартай тушаалаар ЕБС-ийн бага ангийн суралцагчдын математикийн чадварыг нэмэгдүүлэх, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх сургалтын цахим систем нэвтрүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлэхээр баталсан. Түүний хүрээнд 2023-2024 оны хичээлийн жилд үндэсний хэмжээнд 3-4 дүгээр ангид тус цахим платформыг хэрэглэхтэй холбогдуулан нийслэл, орон нутгийн багш нарт дэмжлэг үзүүлэх үндэсний сургагч багш бэлтгэх сургалтыг Финландын Турку их сургуулийн дэргэдэх "Eduten" цахим платформын мэргэжилтэн, БЕГ, БСҮХ хамтран 8 дугаар сарын 23-24-нд зохион байгуулав. Сургалтад НБГ, орон нутгийн БШУГ-ын бага боловсрол хариуцсан мэргэжилтэн, ЕБС-ийн сургалтын менежер, бага боловсролын багш, нийт 65 хүн хамрагдав.

Сургалтын хугацаанд БСҮХ-ийн хийсэн тус платформын туршилтын үр дүн, түүнийг сургалтад ашиглах арга зүй, олон улсын туршлагын талаар мэдээлэл өгч, орон нутагт хийх II шатны сургалтын агуулга, арга зүйн талаар хэлэлцүүлэг өрнүүлэв. "Eduten" платформыг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэхтэй холбоотой менежментийн болон, арга зүйн чиглэлийг танилцуулав.



## СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ТАЛААР ТАЛУУДЫН ОЙЛГОЛТЫГ НЭГТГЭХ УУЛЗАЛТ-ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ХИЙВ.

БШУ-ны сайдын 2023 оны А/221 дугаартай тушаалаар сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал, хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, сурах бичиг зохиох үйл ажиллагааны төлөвлөгөө баталсан. БСҮХ нь сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалыг боловсруулж байгаатай холбогдуулан талуудын ойлголтыг нэгтгэх, үзэл баримтлалыг хэрхэн баталгаажуулах талаарх уулзалт-хэлэлцүүлгийг 8 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулав. Уулзалт-хэлэлцүүлэгт Ерөнхий сайдын зөвлөх Ч.Болортуяа, ЗГХЭГ-ын Салбарын бодлого, зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхцэрэн, Хүний Эрхийг хангах Үндэсний хорооны ажлын албаны дарга Б.Болорсайхан, БШУЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн, БШУЯ-ны боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газар, ерөнхий боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газрын мэргэжилтэн, БСҮХ-ийн удирдлага болон эрдэм шинжилгээний ажилтнууд оролцов. Захирал М.Итгэл оролцогчдод БСҮХ-ийн үйл ажиллагааны чиглэл, цаашдын зорилт болон сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалын төслийг танилцуулсан. Уулзалт-хэлэлцүүлгээр талууд сургалтын хөтөлбөрийг шинэчлэх хэрэгцээ, зорилго зорилт, монгол хүүхдийн эзэмших чадамж, хүмүүжил төлөвшилд чухалчлах үнэт зүйл, хандлагын талаар санал солилцсон. Тухайлбал, сургалтын хөтөлбөрт хүн байх, хариуцлагатай, тэсвэр тэвчээртэй байх, хүний эрхийг дээдлэх болон тэгш хамран сургахыг хэрхэн тусгах, сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд салбарын, салбар дундын оролцоо, тэр дундаа эцэг эхийн оролцоог хангахад анхаарах шаардлагатайг онцоллоо.



**НҮБ-ААС ДЭВШҮҮЛСЭН “ХУВЬСАЖ ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ ТАНИЛЦУУЛАВ.**



**БУЙ БОЛОВСРОЛ” САНААЧИЛГЫН АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨГ**



Х.Отгонбаатар “Хувьсаж буй боловсрол” санаачилгын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг танилцуулсан. Уулзалтад оролцсон элчин сайд болон олон улсын байгууллагын суурин төлөөлөгчид тус төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх хүсэлтээ илэрхийллээ.

Боловсрол Шинжлэх Ухааны яам Гадаад Харилцааны яамтай хамтран Монгол улсад суугаа дэлхийн 50 гаруй улсын элчин сайд, олон улсын байгууллагын суурин төлөөлөгчдийг оролцуулан “Боловсролын шинэ сэргэлт” сэдвийн хүрээнд зөвлөлдөх уулзалтыг 8 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулав. Тус уулзалтад СХҮСБСС-ын эрхлэгч

## **“PEARSON ENGLISH” ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДУУЛАН АНГЛИ ХЭЛНИЙ БАГШ НАРЫН ЗААХ АРГА ЗҮЙН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАВ.**

2023-2024 оны хичээлийн жилд бүх ЕБС-ийн V-VI ангид “Pearson English” англи хэлний сургалтын цогц хөтөлбөр хэрэгжихтэй холбогдуулан үндэсний сургагч багш бэлтгэх, багш нарт арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтыг 08 дугаар сарын 23-26-нд Улаанбаатар хотод, орон нутагт 8 дугаар сарын 27-29-нд зохион байгуулсан. “Pearson English” хөтөлбөрийг туршилтаар хэрэгжүүлсэн 38 сургуулийн болон сургагч багш бэлтгэх Филип Ворвик багшийн сургалтад хамрагдсан 120 багш нар улсын хэмжээнд дээрх ангиудад англи хэлний хичээл заах 400 гаруй багшид хөтөлбөрийн заах арга зүй, дижитал платформыг ашиглах талаар заасан байна.



## **БАГА БОЛОВСРОЛЫН ДҮРСЛЭХ УРЛАГИЙН СУРГАЛТЫН ЗААХ, АРГА ЗҮЙ ЧИГЛЭЛЭЭР БАГШ НАРЫН ТУРШЛАГА СОЛИЛЦОХ СУРГАЛТ, УУЛЗАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ.**



төлөөлөл нийт 10 гаруй хүн оролцов.

Боловсролын Судалгааны Үндэсний Хүрээлэн, “Уншигч” ТББ, Улаанбаатар дунд сургуулийн багш Г. Хонгорзултай хамтран 08 дугаар сарын 14-ны өдөр туршлага солилцох сургалт уулзалтыг хийв. Сургалтад Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, Боловсролын ерөнхий газар, Боловсролын үнэлгээний төв, Боловсролын мэдээлэл, технологийн төв, Ерөнхий боловсролын сургуулийн багш болон төрийн бус байгууллагын

## МОНГОЛ УЛСАД АНХ УДАА ХОС ХЭЛНИЙ СУРГАЛТТАЙ ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН II-V АНГИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ ГАРЫН АВЛАГА, ДАСГАЛ АЖЛЫН ДЭВТЭР, СОНСОХ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН, БАГШИЙН ЗӨВЛӨМЖИЙГ ЦОГЦООР НЬ БОЛОВСРУУЛЖ, БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН БАГШ СУРАГЧДЫН ГАРТ ХҮРГЭЛЭЭ

БСШУЯ-ы сайдын 2021 оны А/338 тушаалаар баталсан Монгол хэлний хичээлийн жишиг хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилготой II-V ангийн гарын авлага, дасгал ажлын дэвтэр, сонсох хэрэглэгдэхүүний хамтаар багш сурагчдын хүртээл болголоо. Энэхүү ажлыг Баян-Өлгий аймгийн хос хэлтэй сурагчдад зориулан Боловсрол, Шинжлэх Ухааны Яам, Дэлхийн банкны хамтран хэрэгжүүлж буй “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн дэмжлэгээр Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн дээр боловсруулж, хэвлэн түгээв.

### Гарын авлага болон дасгал ажлын дэвтэр:

Гарын авлага, дасгал ажлын дэвтэр, сонсох хэрэглэгдэхүүн нь хоорондоо нягт уялдаа холбоотой цогц бүтээл юм. Гарын авлага нь зурагт толь бичиг, унших, бичих чадварыг хөгжүүлэх дасгалуудаас бүрдэх бөгөөд танин мэдэхүйн түвшин, хэлний харилцааны чадварыг харгалзан алхамчилсан, үе шаттайгаар боловсруулсан.

Зураг. II-V ангийн монгол хэлний гарын авлага



Дасгал ажлын дэвтрийн хувьд сонсож ойлгох чадварыг илрүүлэх дасгал даалгавруудаас бүрдэх ба дасгалын дэвтэрт зурж, бичиж ажилладгаараа онцлогтой юм. Бүлэг сэдэв бүрийн төгсгөлд “Өөрийгөө үнэлэе” үнэлгээний даалгаврыг оруулж өгсөн ба жишиг байдлаар ашиглах боломжтой.

### Сонсох хэрэглэгдэхүүн:

II-V ангийн монгол хэлний бүх сурах бичиг сонсох хэрэглэгдэхүүнтэй.

- Гарын авлагын бүлэг сэдэв бүрийн эхэнд шинэ үгийг “Зурагт толь” оруулж, нэг үгийг 3 удаа давтан сонсож, зургийг үгтэй харьцуулан харж, уншиж, давтан хэлж, зөв дуудаж сургах зорилготой.
- Гарын авлагад уншиж ажиллах байдлаар өгсөн эхүүдийг сонсох хэлбэрээр бэлдэж, дасгал ажлын дэвтэрт сонсож ойлгох чадварыг хөгжүүлэх даалгавар болгон оруулсан ба 3 удаа сонсогоор зохион байгуулсан.